



БУЛГАН СУМЫН ЁЛТ ҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор: М.Айнур
Утас: 94159291
Цахим хаяг:
ainurmarkhava@yahoo.com

Хаяг: Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар
Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дах заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /БӨА-2018/117-СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 21-ноос 2 дугаар сарын 11-ны хооронд хийхээр төлөвлөж, Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2017 оны 1 дугаар сарын 22-нд Аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 2 дугаар сарын 22-ноос 2 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2 дугаар сарын 25-нд Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүдийг бэлтгэхэд оршино. Хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Булган сумын төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон

хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад салбарын харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан ажиллаагүй байна.

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “Аколоус” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 30 буюу “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЕЗ-ийн тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн захирагч нь 2017 онд 93,0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулжээ. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 93,0 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзэхэд зардлуудыг төсөвтөө багтаан хэтрэлт, хэмнэлтгүй ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулинд заасны дагуу shilendans.gov.mn вэб сайтанд байгууллагын 2017 оны батлагдсан төсвийн мэдээллийг оруулсан байна. 2017 онд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар Дэлүүн сумын Хүүхдийн цэцэрлэгийн нь мэдээлэлээ бүрэн оруулсан, зөрчил дутагдал гараагүй байна.

2017 оны 10-12 дугаар саруудын шилэн дансны мэдээллийг аудиторын зүгээс шалгаж Shilen dans-ман файлаар баримтжуулж, тайлантай хамт ажлын талбарт хавсаргав.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 2 чиглэлд 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний санхүүжилт орлого, цалин, НДШ, ХХОАТ, түлш халаалт, шатахуун, хоол, гэрэл цахилгаан, төрөөс олгох тэтгэмж зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Тайлант оны онцлог гүйлгээний талаар тодруулбал:

Тайлант онд онцлохоор үйл явдал болоогүй байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй.

1. Батлагдсан орон тооны хязгаар 8 хүн ба гүйцэтгэлээр 10 хүн ажиллуулж, орон тоог 2-оор хэтрүүлж, НДШ, ХХОАТ-т 3407.7 мянган төгрөгийн өглөгийг үүсгэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.3, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дах заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж, Төсвийн тухай хуулийг баримтлаж зөрчлийг арилгаж ажиллахыг албан шаардлагаар үүрэг болгов.

2. Хоолны зардлаас цалингийн зардалд 3489.7 мянган төгрөгийг төрийн сангийн зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулж Сангийн сайдын 2013 оны "төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-т "аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн захирагчаас ирүүлсэн саналыг судлан үзээд зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд тухайн зардлын бүлгийн батлагдсан төсвийн жилийн дүнгийн 120 хувиас хэтрэхгүй, 10.0 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийж баталгаажуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42.3, 42.4 дэх заалтуудыг баримталж ажиллахыг албан шаардлагаар үүрэг болгов.

3. Хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын бүртгэл, тооцоонд хийсэн горим сорилын үр дүнгээр нэг өдрийн зардлын гүйцэтгэл нийтдээ 7 сард 1650 төгрөгөөс дээш дүнтэй зарлагадсан ба жилийн дүнгээр нийтдээ 347,7 мянган төгрөгийн хоолыг илүү зарлага гаргасан байна. Энэ нь Засгийн газрын 2012 оны "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" 106 дугаар тогтоолын 2 дахь заалт "Цэцэрлэгийн хүүхэд нэг бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөгөөр тогтоосугай" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хоолны төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах, зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага өгөв.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Байхгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Дараагийн аудитаар орон тооны асуудлыг анхааралдаа авах нь зүйтэй гэж үзлээ. татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байгаа болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх онд зөвлөмж өгөгдөөгүй байгаа болно.

Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын Ёлт Хүүхдийн цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, хавсралтууд хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.ХУАНГАН

ОГНОО:2018.02.22

Х.ЖЕНИСБЕК

ОГНОО:2018.02.22

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.АЙНУР ОГНОО:2018.02.22